



SHARYN GOL JSC

ШАРЫН ГОЛ ХУВЬЦААТ КОМПАНИ

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд
зориулав

2012 он

Хүндэт хувьцаа эзэмшигчид ээ!

“Шарынгол”ХК-ийн хувьцаа эзэмшигчид та бид 2011 оны компанийн үр дүнг хэлэлцэж тодорхой шийдвэр гаргахаар удахгүй хуралдах гэж байна.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын өмнө компанийн 2011 оны ажил байдлын талаар та бүхэнд танилцуулж байна.

2011 онд манай уурхайчид нийт 1123,7 мян м3 хөрс хуулж, 375,1 мян тн нүүрс олборлон, 365,9 мян тн нүүрс борлуулж Дархан, Эрдэнэтийн ДЦС болон бусад гэрээт хэрэглэгчдийг нүүрсээр хангах үүргээ амжилттай биелүүллээ.

Олон жилийн хөрс хуулалтын хоцрогдол, техник тоног төхөөрөмжийн хуучрал, хөрөнгө санхүүгийн хүндрэлтэй байдал бидний ажилд бэрхшээл учруулсаар байсан ч уурхайчид үндсэн зорилтоо нэр төртөө биелүүлэхийн төлөө хүчин чармайлт гарган ажиллаа.

Бид нийт борлуулсан нүүрсний 75 хувийг засгийн газраас тогтоосон бодит биш үнээр эрчим хүчний үйлдвэрүүдэд нийлүүлсэн бөгөөд уг хэрэглэгчид нийлүүлсэн нүүрсний жинг бууруулах, төлбөрийг нь цаг хугацаанд нь хийхгүй байгаа зэргээс техник тоног төхөөрөмж, сэлбэг материалаар тасалдан үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлсээр байна.

2011 онд нийт 11.569.0 сая төгрөгийн орлого олж 11.147.6 сая төгрөгийн зардал гаргасан байна.

Жил бүр уулын ашиглалтын байдал улам хүндэрч шинэ технологийг нэвтрүүлэх, техникийн шинэчлэл хийх асуудал тулгарч зах зээлийн хувьд ч өргөтгөх, өөрчлөлт хийх зайлшгүй шаардлагатай болсон юм.

Иймээс гадны хөрөнгө оруулагч буюу хувьцаа эзэмшигчдийн шинэ менежментээр нөөц тогтоох нарийвчилсан хайгуулын ажил хийж олон улсын зөвлөх компаниар нүүрсний нөөцөө албан ёсоор батлуулсан билээ.

Албан ёсоор баталгаажуулсан нөөцийн тайланд тулгуурлан шинэ ил уурхайн үйл ажиллагааг эхлүүлэх хөрөнгө төвлөрүүлэх зорилгоор нэмэлт хувьцаа гаргаж зохих хэмжээний санхүүжилтыг татан төвлөрүүллээ.

“Шарынгол”ХК-ийн менежментэд олон улсын туршлагатай мэргэжилтнүүд оролцон ажиллах болсноор компанийн үйл ажиллагааг сайжруулах, дэлхийн стандартад нийцсэн уул уурхайн компани болгох зэрэг зорилтыг дэвшүүлэн ажиллаж, энэ хүрээнд хэд хэдэн томоохон ажлуудыг хийж гүйцэтгэснийг зориуд дурьдаж байна.

2012 оны зорилтыг хэрэгжүүлэхэд та бүхний идэвхтэй үйл ажиллагаа чухал байгааг тэмдэглэж байна.

ТУЗ-ийн дарга

Б.Батмөнх

Хурлын тов: 2012 оны 4 дугаар сарын 30-ний өдрийн 16.00 цагаас

Хурлын байр: “Баянгол” зочид буудлын хурлын танхим.

Хуралд хэлэлцэх асуудал

1. Компанийн 2011 оны үйлвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт бүхий тайлан.
2. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулга
3. Компанийн ТУЗ-ийн гишүүдийн 2012 оны цалин урамшуулал болон зардлын төсөв.
4. Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүдийг сонгох
5. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг мэдээлэх.

Компанийн эрхэм зорилго: Газрын баялгийг гүн боловсруулж, хөдөлмөрийн бүтээмж, бүтээгдэхүүний чанар, харилцагчийн хэрэгцээг эрхэмлэнэ.

“Шарынгол”ХК-ийн танилцуулга.

1. Нэр: “Шарынгол”ХК
Үндсэн харьяалал: Монгол улс
2. Хаяг: Дархан-Уул аймаг Шарынгол сум Санжинт баг
Утас 70372235. Факс 70372235
3. Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл “Засгийн газрын 2003 оны 162 дугаар тогтоол, төрийн өмчийн хорооны 2003 оны 682 дугаар тогтоолоор 100 хувь, хувийн өмчит компани болсон.
4. Улсын бүргэлийн гэрчилгээний дугаар 1910010009, регистерийн дугаар 2050374
5. Тус компани нь чулуун нүүрс олборлон Дархан, Эрдэнэтийн дулааны цахилгаан станц болон бусад гэрээт байгууллага, компаниудад нийлүүлдэг.
6. Компанийн эрх барих дээд байгууллага нь: Хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд компанийн өдөр дутмын үйл ажиллагааг үйл ажиллагаа эрхэлсэн захирал удирдана.

“Шарыngoл”ХК-ийн 2011 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн үйл ажиллагааны талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт, ТУЗ-ийн ажлын тайлан

/Б.Батмөнх –ТУЗ-ийн дарга/

Нэг. 2011 оны уулын ажлын зорилт, түүний биелэлтийн талаар:

2011 онд батлагдсан уулын ажлын төлөвлөгөөний дагуу хөрс хуулалт, нүүрс олборлолтыг явуулсан.

2011 оны уулын ажлын төлөвлөгөөний гүйцэтгэлийг урд онтой харьцуулбал:

Үзүүлэлт	х/н	2010 оны гүйц	2011 оны төл	2011 оны гүйц	2011г/2011г	2011г/2010г
Нүүрс гаргалт	м.тн	422.1	370.0	375.1	101.4	88.9
Нүүрс борлуулалт	м.тн	399.1	370.0	365.9	98.9	91.7
Нийт хөрс	м.м ³	1448.7	2000.0	1123.7	56.2	77.6
Үүнээс:						
- Тээвэргүй	м.м ³	144.5	300.0	32.3	10.8	22.4
- Автаар	м.м ³	1304.2	1700.0	1091.4	64.2	83.7
Нийт у/цул	м.м ³	1773.4	2284.6	1412.3	61.8	79.6
Өрөмдлөг	м.у.м	45.9	45.0	32.9	73.1	71.7

Уулын ажлын өрнөлтийн тухай

Нийт олборлосон нүүрсний 93 хувийг Хойд блокийн үндсэн давхаргаас, 10 хувийг улнаас олборлосон байна.

Хойд блокийн нүүрсний давхарга нь чулууны үе багатай , илчлэг өндөр байсан учраас сайн чанарын нүүрс олборлон хэрэглэгчдэд нийлүүлсэн.

Нүүрс олборлолтонд LC-290 , LC-450 , ЭКГ-4У маркийн экскаваторууд ажилласан.

Хойд блокийн усны ундрага их байснаас ус шүүрүүлэх тусгай зумпф малтаж труба хоолой монтажлан шүүрүүлэлтийг хийснээр нүүрс олборлолт хэвийн явагдсан бөгөөд усны хүндрэлтэй үед гидро экскаваторуудыг илүү ашигласан.

Уулын ажлаас чөлөөлөгдөн сул зогсох экскаватор , өрмийн машинуудыг дээд төвшинд шилжүүлэн ажиллуулахаар төлөвлөж байсан хэдий ч тодорхой шалтгаануудаар энэ ажил хийгдээгүй.

Нийт хөрс хуулалтын ажил өрмийн машинуудын эвдрэл саатал их гарсан болон тээврийн хэрэгсэл хүрэлцээгүй зэрэг шалтгаанаар бүрэн хийгдэж чадаагүй. Үүнээс хамаарч урд блокийн нүүрсийг нээх хугацаа хойшлогдон 2012 онд үргэлжлэн хөрс хуулалт явагдаж байна.

2011 онд гүний уурхайн штрект галын голомт үүсч халалт үүссэн нь онцгой байдал бий болгосон. Галын голомтыг дарах техник зохион байгуулалтын арга хэмжээнүүдийг дэс дараалалтай авч хэрэгжүүлж ажилласан.

2011 оны уулын ажлын өрнөлтийн гол зорилт нь Шаазгайтын талбайд шинэ уурхай нээж нүүрс олборлох боломж бүрдэх хугацаанд нүүрс олборлолтыг тасалдалгүй явуулах бололцоог бүрдүүлэх явдал байсан бөгөөд энэ зорилтоо тодорхой хэмжээнд хангасан гэж үзэж байна.

2012 оны Уулын ажлын өрнөлтийн үндсэн зорилт

2012 онд одоогийн ашиглалт явагдаж байгаа үндсэн уурхайн хойд болон урд блокоос нийт 300.0 мян.тн нүүрс олборлохоор тооцон төлөвлөгөө боловсруулан холбогдох мэргэжлийн ба хяналтын байгууллагуудаар батлуулан ажиллаж байна. Урд блокоос нүүрс олборлох боломжийг бүрдүүлэхийн тулд нүүрсний давхаргын таазны хөрс 116.0 м.м³-ийг хуулна. 2012 оны уулын ажлын өрнөлтийг хангах гол зорилт нь :

- Хойд блокод үлдсэн нүүрсийг бүрэн олборлоно. (2012 оны 1,2-р улирал)
- Урд блокийн нүүрсний давхаргыг нээж дуусган нүүрс олборлоно.
- Нүүрсний давхаргын дундах чулууны үеийн ялгалтыг маш сайн хийж чанарын төвшинг хадгална.
- Сул зогсож байгаа экскаваторуудыг одоогийн ашиглалт явагдаж байгаа уурхайн дээд төвшингүүдэд байрлуулж хөрс хуулалт , шидэлт , инженерийн ажил хийж уулын нуралт гулсалтаас урьдчилан сэргийлэх , дараагийн хөрс хуулалтын ажлын талбай бэлтгэх боломж бүрдүүлнэ.
- Шаазгайтын талбайд шинэ уурхай нээх бэлтгэл хангаж хөрс хуулалтын ажлыг эхлүүлнэ. 2012 оны 11-р сар гэхэд шинэ уурхайд нүүрсний нөөц нээж 2012-2013 онд олборлох бэлтгэл хангана.
- Зогсож байгаа болон одоо ажиллаж байгаа экскаватор , өрмийн машинуудын сэлбэгийг яаралтай олж нийлүүлэн засварын ажлыг чанартай хийнэ.
- Хүнд даацын автосамосвал шинээр худалдан авч ашиглалтанд оруулна.
- Байгаль орчин хамгаалах удирдлагын менежментийг сайжруулах, төлөвлөгөөт нөхөн сэргээлтийн ажлуудыг бүрэн хийж гүйцэтгэнэ.
- Ус шүүрүүлэлтийн системийн хэвийн ажиллагааг хангаж цаашдын үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлно.
- **Техникийн байдал, засвар үйлчилгээ, хөрөнгө оруулалтын тухай:**
- 2011 онд уулын үндсэн тоног төхөөрөмж 10 экскаватораас ЭШ 10/70 №28 генераторгүй зогссон, экскаватор 5А №20 засвар хийгээд бэлтгэлд /шанаганы шүд байхгүй байснаас/ зогссон. Нийт 8 экскаватор ажилласан бөгөөд засварын ажил графикайн дагуу 100% хийгдсэн.
- Нийт 4 өрмийн машинаас 5СБШ-200-ийн компрессорын тоног төхөөрөмжийг өрөм №34-д шилжүүлж тавьсан. 3 өрөм ажилласнаас өрөм СБР 160 №29-ийн явах

- анги, СБШ -250 №35-ийн сумны засвар, СБШ-200 №34-ийн компрессор, гидрийн системд тус тус засвар хийсэн.
- Тээврийн хэрэгслийн хангалт муу байсан. 4 КАТ 769-ийг ээлж дараалан засвар хийсэн боловч зарим эд анги ГТЭ, киви, моторын сэлбэг олдохгүйгээс зогсолт саатал их гарсан. Мөн 4 Нова мотор, коробканы эвдрэл гарч зогсолт саатал их байсан.
 - Экс HL 290, 450 тус бүрд нь моторын засвар хийсэн боловч найдвартай ажиллагаа сайн хангахгүй байна. Бүтээлтэй ажилласан цагаар нь тооцож үзвэл 40-43% байгаа нь цаашид ашиглах ашиглалтын зардал ихсэж байгааг харуулж байна.
 - Тээврийн хэрэгсэл том даацын КАТ 773 2-3 ширхэг авах шаардлагатай байна. Мөн урвуу шанагат экскаваторын шаардлага байгаа учир шинээр КАТ 345 маркийн экскаватор 1 ширхэг авах шаардлагатай.
 - Дамжлага, илчит тэрэг 1286, экскаватор №20-д засварын ажлыг 6-7-р сард графикийн дагуу бүрэн хийж дуусгасан.
 - 11011 онд 464.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан. Үүнд: Зам усалгааны Нова машин, Chantui маркийн бульдозер, ажилчдыг тээвэрлэх Daewoo автобус, плоттер, сервер компьютер, DIAMOND санхүүгийн программ, ажилчдын хувцас угаах, хатаах, индүүдэх иж бүрэн төхөөрөмж худалдан авсан.
 - Судалгаанаас үзэхэд насжилт өндөртэй экскаваторын ашиглалт 40.6%, өрмийн машины ашиглалт 20.4%, автосамосвалын ашиглалт 43.5%-тай байгаа нь техник, технологийн шинэчлэл хийх шаардлагатайг харуулж байна.
 - Тээврийн машинуудаас КАТ №34 нь 216.6 мян.м³ уулын цул тээвэрлэн хамгийн өндөр амжилт үзүүлсэн байна.

Хоёр: 2011 оны санхүүгийн үйл ажиллагааны талаар:

А.Борлуулалтын төлөвлөгөөний биелэлт

- 2011 онд 1,123.7 мян.м³ хөрс хуулж, 375.1 мян. тн нүүрс олборлон, 365.9 мян.тн нүүрс борлуулсанаас Дархан , Эрдэнэтийн ДЦС-уудад 274.4 мян тн нүүрс нийлүүлж гэрээгээр хүлээсэн үүргээ Дархан ДЦС-д 136.9%-иар, Эрдэнэт ДЦС-д 137.5%-иар тус тус биелүүлсэн.
- Орон нутгийн томоохон үйлдвэрүүд болох “Эрэл цемент”, “Дархан Силикат”, “Дархан Хар төмөрлөг” зэрэг аж ахуйн нэгжүүд, Төв, Сэлэнгэ, Орхон, Дархан-Уул аймгуудын бага оврын уурын зуухтай төсвийн байгууллагууд, ард иргэдийн түлшний хэрэгцээг найдвартай хангаж ажиллаа.

2011 онд борлуулсан нүүрс /хэрэглэгчээр/

Хэрэглэгчид	2010 оны гүйц м.тн	2011 оны /м.тн/		Биелэлт /хувь/	Зөрүү м.тн
		Төлөв	Гүйц		
Дархан ТЭЦ	134.4	100.0	136.9	136.9	36.9
Эрдэнэт ТЭЦ	135.2	100.0	137.5	137.5	37.5

Эрэл цемент	50.7	55.0	18.0	32.7	-37.0
Дулаан ШГ	11.3	15.0	12.4	82.7	-2.6
Хансогоо ХХК	8.0	5.0	6.6	132.0	1.6
Нако түлш		40.0	1.1	2.8	-38.9
Автаар	29.2	15.0	34.9	232.7	19.9
бусад	31.1	40.0	18.5	45.3	-21.5
дүн	399.9	370.0	365.9	98.9	-4.1

Орлогын төлөвлөгөөний биелэлт /сая.төг/

Үзүүлэлт	2010 оны гүйц	2011 оны		Биелэлт /хувь/
		Төлөв	Гүйц	
Үндсэн үйл ажиллагааны орлого	9,955.9	10,325.5	10,543.5	102.1
Туслах үйлдвэрлэлийн орлого	89.9	87.2	84.5	96.9
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	890.8	35.5	941.0	26.5 дах
ДҮН	10,936.6	10,448.2	11,569.0	110.7

Тайлант онд үндсэн үйл ажиллагаанаас буюу нүүрсний борлуулалтаас 10,543.5 сая төгрөг, туслах үйлдвэрээс 84.5 сая төгрөг, үндсэн бус үйл ажиллагаанаас 941.0 сая төгрөгний орлого нийт 11,569.0 сая төгрөгний орлого олсон байна.

Б. Орлого, зардал, ашиг алдагдал /сая төгрөг/

Нэр төрөл	Орлого	Зарлага	Ашиг, алдагдал
Нүүрс	10,543.4	10,438.5	104.9
ТАА	32.3	26.5	5.8
Амралт, спорт ордон	9.8	61.9	-52.1
Цайны газар	34.4	107.3	-72.9
Түрээс	91.1		91.1
Амрах байр	7.5	29.3	-21.8
Сэлбэг борлуулсны	31.6	23.8	7.8
Хаягдал төмрийн	73.4	1.7	71.7
Ханшны зөрүү, хүү	267.6	65.9	201.7
Үндсэн хөрөнгө борлуулсны		32.8	-32.8
Торгуулийн	3.7	5.3	-1.6
ЭЗНХС-ийн зарцуулалт		200.3	-200.3
Найдваргүй авлага	341.1		341.1
Татварын зардал		149.1	-149.1
Бусад	133.1	5.2	127.9
Татварын дараах ашиг	11,569.0	11,147.6	421.4

2011 онд 11,569.0 сая төгрөгний орлого олж, 11,147.6 сая төгрөгний зардал гарган 421.4 сая төгрөгний ашигтай ажилласан байна.

2011 онд жингийн зөрүүнээс 27.3 сая төгрөг алдаж, илчлэгийн зөрүүнээс 71.5 сая төгрөгийг авсан байна.

В.Өртөг зардлын талаар

2011 онд нүүрсний үйлдвэрийн зардалд 10,774.1 сая төгрөгөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 10,438.5 сая төгрөгний зардал гаргаж төлөвлөсөн зардлаас 335.6 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Зардлын талаар:

Тэсрэх материал 338.9 тн-ыг 638.8 сая төгрөгөөр авахаар төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 240.0 тн-ыг 443.7 сая төгрөгөөр авч 195.1 сая төг хэмнэсэн байна. Тэслэгдэх уулын цулын хэмжээ 518.3 м.м³-ээр тасарсан байна. Нэгжид ногдох тэсрэх материалын хэмжээ 0.042 кг/м³-ээр төлөвлөсөн хэмжээнээс бага зарцуулсан нь биетээр 10.08 тн, үнийн дүнгээр 18.6 сая.төгрөгийг хэмнэсэн байна.

1,984.6 м.м³ у/цулыг 604.2 м.литр буюу 725.0 сая төгрөгөөр тээвэрлэхээр төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 1,379.9 м.м³ у/цулыг 524.3 м.л буюу 737.3 сая төгрөгний дизелийн түлшээр тээвэрлэсэн байна. Нэгжид ногдох түлш төлөвлөсөн хэмжээнээс 0.076 л/м³-ээр хэтэрсэн нь 104.9 м.л буюу 147.4 сая төгрөгний хэтрэлт нь гарсан байна.


2011 онд 473 ажилчинд 2,312.9 сая төгрөгний цалин олгохоор төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр 414 ажилчинд 2,059.6 сая төгрөг олгосон байна. Төлөвлөсөн хэмжээнээс 59 /далд хэсгийн 22 ажилчин орсон/ орон тоо цөөрч үүнээс 194.3 сая төг-өөр цалингийн зардлыг хэмнэсэн байна. 2011 оны 9-р сараас 20%-иар цалин нэмсэн бөгөөд ажилчдын сарын дундаж цалин 415.1 мян төг байна.

2011 онд хөдөлмөр хамгааллын зардалд 95.0 сая төгрөг зарцуулсан бөгөөд ажиллагсадын хувцас хамгаалах хэрэгсэлд 21.6 сая төг, шөнийн хоол, хор саармагжуулах бүтээгдэхүүнд 34.1 сая төгрөг , хөдөлмөр хамгааллын бусад зардал 39.3 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.


2011 онд автаар 1,379.9 мян м³ у/цулыг тээвэрлэснээс түрээсийн машинууд нь 253.4 м.м³ у/цул буюу 18.4 %-ийг тээвэрлэсэн байна. Дээрх гүйцэтгэсэн ажил- /түрээсийн зардал/-д 214.5 сая төгрөг олгосон байна.

Засвар үйлчилгээний зардлын хувьд 112.5 сая төгрөг зарцуулснаас КАТ-уудын засвар үйлчилгээний зардалд 82.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

2011 оны зардлын бүтэц



Г. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн сангийн зарцуулалт



Д. Худалдаж авсан үндсэн хөрөнгө

2011 онд 644.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдаж авсан байна. Үүнд:

	сая.төг
Зам услах Хова автосамосвал	70.3
Нүүрс ачих бункер	4.0
Автобус	10.5
Саната 5	10.0
Ланд-200	103.5
Чанту бульдозер	237.7
Lexus -470	83.7
Насос Д32-50 75 квт	9.6
Насос ЦНС300-240	68.2
Ажилчдын хувцас угаах төх-ж	10.7
Ком 2ш, принтер 2 ш, плоттер	20.3
Санхүүгийн програм	10.4
Бусад	5.5

Е. Авлага, өглөгийн талаар: Авлага /сая.төг/

Авлагын төрөл	Оны эхэнд	Оны эцэст	Зөрүү
Нүүрсээр авах авлага	1,204.5	402.0	-802.5
Сэлбэг материалаар	1,205.2	430.0	-775.2
Хүмүүсээс авах авлага	1.2	7.7	6.5
Цахилгаанаар	50.9	6.4	-44.5
Халамжийн сангаас	4.7	4.8	0.1
Дараа тайлангаар	83.1	21.5	-61.6
Дансны авлага	182.7	321.5	138.8
Богино хугацаат зээл	2,936.6		2,936.6
Зээлийн хүүгийн авлага	80.5	1.5	-79.0
НӨАТ-ын авлага		7.7	7.7
ДҮН	5749,4	1,203,1	-4,546.3
Эрэл хайгуулын зардал	5,746.0	6,753.9	

Нүүрсээр авах авлага /сая.төг/

Хэрэглэгч	Оны эхний үлдэгдэл	2011 онд авсан	2011 онд төлсөн	Улирлын эцэст
Дархан ТЭЦ	513.1	3,978.3	4,354.5	136.9
Эрэл цемент	102.1	675.5	758.5	19.1
Шарын гол Энерго	71.5		71.5	
Хансогоо ХХК	19.9	175.7	178.6	17.0
Дулаан ШГ		384.7	316.0	68.6
Эрдэнэт ГОК	71.2		71.2	
Эрдэнэт ТЭЦ	364.0	4,029.7	4,287.2	106.5

Өглөг /сая.төг/

Өглөгийн төрөл	Оны эхэнд	Оны эцэст	Зөрүү
Бүх төрлийн татварт	493.9	416.7	-77.2
НДШ	23.9	0.6	-23.3
Урт хугацаат өглөг	2,508.3	2,508.3	-
Сэлбэг материалын	507.8	160.2	-347.6
Нүүрсний	37.9	25.9	-12.0
Хүмүүст	22.7	16.3	-6.4
Цалингийн	86.2	98.9	12.7
Богино хугацаат зээл	10,422.0	467.9	-9,954.1
Богино хугацаат зээлийн хүү	154.4	36.2	-118.2
Хуримтлал тооцсон	78.2	16.1	-62.1
Дансны өглөг	369.5	749.2	379.7
өглөгийн дүн	14,704.8	4,496.3	-10,208.5

Ё. Татвар төлөлт:

2011 онд 2,125.0 сая төгрөгийн татварыг улс болон орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Татварын төрөл	Эх үлдэгдэл	Төлбөл зохих	Төлсөн	Эцсийн үлдэгдэл
БОАТ	69.4	207.8	277.5	-0.3
ХАОАТ	58.7	217.3	271.5	4.5
НӨАТ	-0.1	1,094.3	1,101.9	-7.7
Нөөцийн татвар	15.0	263.2	277.2	1.0
Тээврийн хэрэгслийн албан татвар		2.2	2.2	-
Газар, усны татвар		74.5	74.5	
ҮХХАТатвар		19.1	19.1	
Агаарын бохирдол		132.5	101.0	31.5
ДҮН	143.0	2,011.0	2,125.0	29.0
НДШ	23.9	554.7	578.0	0.6

Ж. Санхүүгийн шалгуур үзүүлэлтүүд

Үндсэн өгөгдөл

/сая төгрөг/

д/д	үндсэн үзүүлэлт	2010 он	2011 он
1	мөнгөн хөрөнгө	1,817.9	17,591.3
2	ТБҮЦ	-	-
3	Авлага	5,057.2	932.0
4	БХӨТ	12,196.7	1,953.9
5	эргэлтийн актив	8,421.5	20,004.9
6	эргэлтийн пассив	14,117.1	16,572.6

Хувьцаа эзэмшигчдийн хурлын материал

7	цэвэр ашиг	215.0	421.4
8	борлуулалт	9,955.9	10,543.5
9	эзэмшигчдийн өмч	7,833.7	32,115.3
10	үндсэн хөрөнгө	8,663.4	9,234.9
11	нийт хөрөнгө	22,538.6	36,577.6
12	нийт өр төлбөр	14,705.0	4,462.2
13	үндсэн хөрөнгийн дундаж өртөг	8,663.4	9,234.9
14	борлуулсан барааны өртөг	7,245.8	8,149.7
15	бараа материал	1,362.3	1,297.6

харьцаа

д/д	үзүүлэлт	2010 он	2011 он
1	эргэлтийн хөрөнгийн харьцаа	0.69	10.24
2	түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа	0.56	9.48
3	ажлын цэвэр капитал	(3,775.11)	18,051.04
4	мөнгөний эргэлтийн харьцаа	14.90	900.31
5	өр төлбөр эзэмшигчийн өмчийн харьцаа	53.27	719.71
6	Цэвэр ашгийн харьцаа	0.03	0.01
7	Борлуулалтын хөрөнгийн өгөөж	0.02	0.04
8	өөрийн хөрөнгийн өгөөж	(0.06)	0.02
9	хөрөнгийн өгөөжийн түвшин	44.17	28.82
10	үндсэн хөрөнгө ба эзэмшигчийн өмчийн харьцаа	90.42	347.76
11	хөрөнгийн эргэц	114.92	114.17

12	Авлагын эргэц (удаа)	1.97	11.31
13	Авлагын эргэц (өдөр)	183	32
14	Өглөгийн эргэц (удаа)	0.69	10.24
15	Өглөгийн эргэц (өдөр)	521	35
16	Бараа материалын эргэц	7.3	8.1
17	нөөцийн эргэц (удаа)	5.3	6.3
18	нөөцийн эргэц (өдөр)	68	57
19	Үйлдвэрийн циклийн хугацаа	251	89
20	Санхүүгийн циклийн хугацаа	(271)	54

Гурав: Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын талаар

“Шарынгол”ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь өнгөрсөн тайлант хугацаанд компанийн үйлдвэрлэл, удирдлага зохион байгуулалт санхүү эдийн засгийн асуудлаар зайлшгүй шийдвэл зохих 45 асуудал хэлэлцэж, тухай бүрд нь хурлын тэмдэглэл хөтөлж холбогдох тогтоол шийдвэр гаргасан байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн байдаг орон зайгаас шалтгаалан ТУЗ-ийн хурлыг хоёр хэлбэрээр хийж байсан юм. Гишүүдийн биечлэн оролцсон хурлыг 6 удаа хийж 32 асуудал, зарим яаралтай шийдэх асуудлыг шийдвэрлэхийн тулд цахилгаан шуудангаар /онлайн/ санал авах хурлыг 14 удаа хийж 14 асуудлыг хэлэлцэн шийдвэр гаргалаа.

Тайлант хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудлыг ангилан үзвэл:

- a. Компанийн бизнес төлөвлөгөө, Жорк өрмийн программын тухай, шинээр тогтоосон нүүрсний нөөцийн тухай, Эрдэс баялагийн зөвлөлөөр нөөц батлуулах, шинэ уурхайн зөвшөөрлийн тухай гэх мэт үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай холбогдсон 8 асуудал,
- b. Компанийн санхүүгийн тайлан баланс, нэмэлт хувьцаатай холбогдсон асуудал, цалин хөлс, өр зээл, нүүрсний үнийн тухай, гэрээ хэлцэл, аудитын байгууллагатай холбоотой зэрэг компанийн санхүү эдийн засгийн асуудалтай холбогдсон 25 асуудал
- c. Компанийн ТУЗ-ийн дарга гишүүдийг сонгох,аудитын компани сонгох, удирдах ажилтны гүйцэтгэлийн хариуцлагатай холбогдсон асуудал, компанийн дүрэм журамд өөрчлөлт оруулах, хувь нийлүүлэгчдийн болон төлөөлөн удирдах зөвлөлийн ажил зэрэг удирдлага зохион байгуулалттай холбогдсон 9 асуудал

- d. ТУЗ-ийн тамга тэмдэгийн тухай, бүтээн байгуулалт ойн арга хэмжээнд зориулсан хандивын тухай, спорт ордныг шилжүүлэх тухай, ус шүүрүүлэх хэсэгт гарсан галын тухай гэх мэт бусад 3 асуудал хэлэлцсэн байна.

ТУЗ-ийн хуралд хэлэлцсэн асуудлаар нийт 30 тогтоол гаргасан бөгөөд 13 асуудлыг мэдээлэл ярилцлагын хэлбэрээр сонсгон шийдэж байв.

ТУЗ-ийн хурлаас гарсан гол гол тогтоолын биелэлтийн талаар дурьдвал:

- ❖ Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн 2011 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэж жилдээ 2000.0 мян м3 хөрс хуулж 370,0 мян тн нүүрс олборлож борлуулах төлөвлөгөө өгөгдсөнөөс 1123,7 мян м3 хөрс хуулж, 375.1 мян.тн нүүрс олборлож 365,9 мян.тн нүүрс борлуулсан байна. Хөрс хуулалтын төлөвлөгөө биелээгүй гол шалтгаан нь өрмийн машинуудын эвдрэл саатал их гарсан бөгөөд тээврийн хэрэгсэл хүрэлцээгүй зэрэг гол хүчин зүйл нөлөөлсөн байна.

Үүнээс хамаарч урд блокийн нүүрсийг нээх хугацаа хойшлогдоход хүрлээ.

- ❖ Уурхайн 2012 оны үндсэн төлөвлөгөө болон хэтийн төлөвийн тухай асуудлыг хэлэлцээд 2012 онд хуулах нийт хөрсний хэмжээг 1.200.0 мян м3, нүүрс олборлолт, борлуулалтын хэмжээг 300,0 мян тн байлгах аар тогтосон бөгөөд дээрх үндсэн үзүүлэлтийг 2012 оны бизнес төлөвлөгөөнд тусгасан байгаа.

Уулын ашиглалтын байдал улам хүндэрч техник технологийн хүрэлцээ муудаж байгаа боловч урд блокоос нүүрс олборлох боломжийг бүрдүүлэхийн тулд нүүрсний таазын 116,0 мян м3 хөрсийг хуулж тэндээс нүүрс олборлох. Мөн Шаазгайтын талбайд шинэ уурхай нээх бэлтгэл

хангаж хөрс хуулалтын ажлыг эхлүүлэх. Улмаар 2012 оны 11 дүгээр сар гэхэд шинэ уурхайд нүүрсний нөөц нээж 2012 – 2013 онд олборлолт явуулах бэлтгэл хангагдсан байх ёстой.

Бэрхшээл хүндрэл байгаа боловч нэгэнт төлөвлөгдсөн ажлыг биелүүлэхийн тулд ТУЗ-өөс анхаарч удирдамж чиглэл өгч ажиллах шаардлагатай гэж үзэж байна.

- ❖ 2011 онд гүний уурхайн штрект галын голомт үүсч халалт гарсан нь онцгой байдал бий болгосон. Галын голомтыг дарах техник зохион байгуулалтын арга хэмжээ авахыг ТУЗ-ийн 2011 оны 11 дүгээр сарын 18-ны хурлаас үүрэг чиглэл өгсөн юм. Энэ ажлын явцыг байнга анхаарч байсны үр дүнд хүнд байдлаас гарч байна. Цаашдаа ус шүүрүүлэлтийн системийн хэвийн ажиллагааг хангаж цаашдын үйл ажиллагааны чиглэлийг зөв тодорхойлж аюулгүй байдлыг хангах талаар онцгой анхаарах ёстой.

- ❖ 2011 оны онцлох үйл ажиллагаа бол үйлдвэрлэлийн үйл ажиллагааг цаашид хэвийн явуулах зорилгоор санхүүгийн асуудлыг шийдвэрдэх хөрөнгө босгох явдал байлаа. Энэ асуудал ТУЗ-ийн гол анхаарлын төвд байсан юм. ТУЗ, энэ чиглэлээр хэд хэдэн тогтоол гаргасан байна. Үүний үр дүнд санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 27 дугаар тогтоолоор 1.292.596 ширхэг энгийн хувцааг “Файрборд глобал мастер фанд” , “Файрборд глобал мастер фанд 2 “ ,

Файрборд Монголия фанд” сангуудаас “Шарынгол”ХК-д олгосон 5.456.049.121.98 төгрөгийн зээлийн оронд хөрвүүлэхээр нэмж гаргасан байна. Дээрхи сангуудын өрийг хувьцаанд хөрвүүлэн дансанд тусгасан юм. Мөн санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 8 дугаар сарын 24 – ний өдрийн 250 дугаар тогтоолоор 1.707.404. ширхэг энгийн хувьцааг нэмж гаргахыг зөвшөөрсөн байна. Дээрхи хувьцааг арилжаанд оруулснаар нийт 18,3 тэрбум төгрөгийн татан төвлөрүүлж хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг бий болголоо.

Уг асуудлыг “Үндэсний уул уурхайн компаниуд шаардлагатай хөрөнгө оруулалт, санхүүжилтээ дотоодын хөрөнгийн зах зээлээс татан төвлөрүүлэх боломжтойг илтгэн харууллаа” гэж мэргэжилтнүүд дүгнэсэн байна. Тус компанийн менежментэд олон улсын туршлагатай мэргэжилтнүүд оролцон ажилласнаар компанийн үйл ажиллагааг сайжруулах, дэлхийн стандартад нийцсэн уул уурхайн компани болгох зэрэг зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна.

ТУЗ-ийн хурлаас “ нэмэлт нэмэлт хувьцааны орлогын гүйлгээний тухай” асуудлыг хэлэлцээд уг арилжаалагдсан хувьцааны орлогыг банканд байрлуулан тодорхой дансаар гүйлгээ хийхдээ ТУЗ-ийн дарга, санхүү эрхэлсэн захирлын гарын үсгээр хийх . Данснаас гарах зардал, тооцооны

жагсаалтыг зөвхөн ТУЗ батлаж, ТУЗ-ийн шийдвэргүйгээр төлбөр тооцоо хийхгүй байх. Дансаар хийгдэх ажил гүйлгээний жагсаалтыг 5 байдлаар хийхээр батлах зэргээр шийдсэн юм. Энэ тогтоолын заалтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

- ❖ ТУЗ-ийн хурлаар Шаазгайтын талбайд шинэ уурхай нээхтэй холбогдуулан уг уурхайн талбайд шинээр ам нээх, үндсэн орол гаргах бэлтгэл хангах зорилготой ойрхон зайтай сетка бүхий өрөмдлөг хийх, овоолгын талбайг шинээр бэлтгэх өрмийн ажлын зардлын төсвийг батлан “Элехкор Дриллинг”ХХК-тай гэрээ байгуулан ажилласан.
- ❖ Мөн үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай уялдуулан ТУЗ-ийн хуралд “Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээний тухай хэлэлцэж гаргасан тогтоолын дагуу “Микромайни”компанитай энэ чиглэлээр гэрээ байгуулан ажиллаж байна.
- ❖ ТУЗ-ийн хурлаас тус компаниас гэрээт хэрэглэгчдэд нийлүүлэх 1 тн нүүрсний үнийг 2011 оны 5 дугаар сарын 10-ны өдрөөс 50 000 төгрөгөөр тогтоосон тогтоол гаргасны дагуу нийлүүлж байна. Харин эрчим хүч үйлдвэрлэхэд ашиглах зориулалтаар нийлүүлэх 1 тн нүүрсний суурь үнийг 2012 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 26 275 төгрөгөөр нийлүүлэхээр шийдвэр гарган мөрдсөөр байна. Энэ нь 1 тн нүүрсний бүрэн өөрийн өртөгөөс доогуур байгаа учир цаашид нүүрсний үнийг бодит байдлаар нэмэгдүүлэн борлуулах, ялангуяа эрчим хүч үйлдвэрлэх зориулалтаар худалдан борлуулах нүүрсний үнийг зах зээлийн хуулийн дагуу чөлөөлөх асуудал зайлшгүй тавигдах ёстой гэж ТУЗ үзсээр байна.
- ❖ Компанийн захиргаа, үйлдвэрчний эвлэлийн байгууллагын хооронд байгуулсан хамтын гэрээний заалт, бараа үйлчилгээний үнийн өсөлттэй уялдуулан компанийн нийт ажиллагсдын цалинг 2011 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс 20хувиар нэмэгдүүлж олгохоор тогтсон нь мөрдөгдсөөр байна. Ажиллагсдын цалин хөлсний

талаар цаашид орлогын байдалтай холбогдуулан өсгөх чиглэл баримталж ажиллах зайлшгүй шаарлагатай байна.

- ❖ ТУЗ-өөс “Холбоотой талуудтай хийх гэрээ хэлцлийн тухай асуудлыг хэлэлцээд шийдвэр гаргасны дагуу аливаа холбоотой талуудтай хийх гэрээ хэлцлийн төслийг тус компанийн санхүү эрхэлсэн захирлын зөвшөөрлөөр ТУЗ-ийн хурлаар хэлэлцэж шийдэж байх. Ийм гэрээ хэлцлийн талаар сонирхлын зөрчил бүхий ТУЗ-ийн гишүүн санал өгөх эрхгүй байхаар тогтсон бөгөөд энэ журмыг мөрдөн ажиллаж байна.
- ❖ ТУЗ-ийн хурлаар тус компанид хийсэн “Эрнест Энд Янг” аудитын компанийн зөвлөмж, компанийн санхүү эрхэлсэн захирлын саналыг хэлэлцээд жагсаалтанд байгаа нийт 124,222,077,08 төгрөгийн дүн бүхий өндөр насжилттай өглөгийг компанийн данснаас хасах шийдвэр гаргаж

хэрэгжүүлснээр дансны үлдэгдлийг багасгаж цэвэрлэсэн. Цаашид өр, төлбөр, өглөг авлагыг цаг тухайд нь шийдэж барагдуулж байх нь бидний хийвэл зохих ажлын нэг юм.

- ❖ Компанийн ТУЗ-ийн шийдвэрээр “Сүлд Аудит” ХХК-ийг 2011 оны 1 дүгээр сарын 01-нээс 2011 оны 12 дугаар сарын 31-нийг дуустал хугацаагаар сонгож гэрээ байгуулсан бөгөөд тус компанийн 2011 оны санхүүгийн жилийн аудиторoor “Эрнест Энд Янг” ХХК-ийг томилж аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулан ажиллаа. Сүлд – Аудит” ХХК – нь “Шарынгол”ХК-ийн 2011 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд / Шарынгол ХК-ийн 2011 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн тайлангууд нь санхүүгийн байдал хийгээд тухайд өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бодитой илэрхийлсэн байна / гэж дүгнэсэн юм.

Цаашид жилийн эцсийн аудитыг хийж гүйцэтгэх явцад ажиглагдсан алдаа зөрчлүүдийг засч залруулах, дотоод хяналтыг улам сайжруулан, анхаарвал зохих зөвлөмж өгсөн байна.

Тухайлбал:

- Санхүүгийн программ хангамжиндаа бусад авлага өглөгийг хувь хүн, байгууллагаар нь тус тусад нь данс нээж, дараа тайлангаар олгож байгаа мөнгийг дараа тайлангийн данс нээж бүртгэж байх.
- Машин техникт олгож байгаа түлш шатахууныг жолоочын замын хуудсын дагуу тухайн техникийн норт нормативаар нь тооцоо хийж зардалд шингээж байх. Машин техникт олгож байгаа сэлбэг хэрэгслийг авто машин механизмын хувийн хэрэгт нарийн бүртгэж хөтөлж байх
- Байгууллагын хөрөнгөнд бүртгэлтэй байгаа барилга байгууламжуудад барилгын паспорт нээн, тухайн хөрөнгөнд хийсэн засвар болон хөрөнгө оруулалтын талаар нөхөж бүртгэн паспортжуулах гэжээ.

Аудитын өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажил хэрэг болгох нь бидний бас нэг зорилт байх ёстой

- ❖ Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлах, түүнийг бэлтгэх, зохион байгуулах комисс томилж

компанийн тухай хууль, компанийн дүрэмд заасан хугацаанд зохих журмын дагуу хуралдуулж холбогдох асуудлыг тайлагнан хэлэлцүүлж хувьцаа эзэмшигчдийн үнэлэлт гаргуулах, шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулж байв.

- ❖ “Шарынгол”ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2011 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр хуралдаж компанийн 2010 оны үйдвэрлэлийн болон санхүүгийн үйл ажиллагааны талаарх ТУЗ-ийн дүгнэлт тайлан, ХШЗ-ийн 2010 оны ажлын тайлан, компанийн ТУЗ, ХШЗ-ийн 2011 оны зардлын төсөв зэрэг асуудлыг хэлэлцсэн юм. Уг хуралд нийт саналын

эрхтэй энгийн хувьцаа эзэмшигчдийн 89,5 хувь санал ирүүлсэн бөгөөд хэлэлцэж буй асуудалтай холбогдож гаргасан хурлын шийдвэрийг 99,9-100,0 хувийн саналаар баталсан байна.

- ❖ “Шарынгол”ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2011 оны 10 дугаар сарын 21-нд хуралдаж “Компанийн үйл ажиллагааны өнөөгийн байдал, үйл ажиллагааны цаашдын төлөвлөгөө” “Компанийн ХШЗ-ийн мэдээлэл”, ТУЗ-ийн гишүүдийг сонгох, ХШЗ-ийн гишүүдийг сонгох, ТУЗ болон ХШЗ-ийн тайлант хугацааны зардлын төсөв зэргийг хэлэлцсэн юм. Уг хуралд нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 92,2 хувь нь санал ирүүлсэн бөгөөд хэлэлцэж буй асуудалтай холбогдож гаргасан хурлын шийдвэрийг 100 хувийн саналаар баталсан байна.

- ❖ “Шарынгол”ХК-нь 2012 оны 3 дугаар сарын 16-ны байдлаар 10.231.389 ширхэг энгийн хувьцаатай бөгөөд 1.150 хувьцаа эзэмшигч манай хувьцааг эзэмшиж байна. Тус компанийн хувьцаа “Үнэт цаасны төлбөр тооцоо хадгаламжийн төв” ХХК-д хадгалагдаж байдаг бөгөөд үнэт цаас хадгаламжийн болон үнэт цаастай холбогдолтой төлбөр гүйцэтгэх гэрээг 2 тал жил бүр баталгаажуулан ажиллаж ирлээ.

“Шарынгол”ХК-ийн хувьцаа нь “Би Ди Сек”, “Булган брокер”, “Нэйшнл сэкюритис” зэрэг брокер диллерийн компаниудад төвлөрсөн байна.

Компанийн ТУЗ нь Монгол улсын компанийн тухай хууль, компанийн дүрмийг үндэс болгон цаашдын үйл ажиллагааны мөрдлөг болгон ажиллах болно.

Анхаарал тавьсанд баярлалаа



**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2012 оны 3 сарын 02 өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

Компанийн 2011 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны
болон санхүүгийн тайлангийн талаарх
ТУЗ-ийн дүгнэлтийн тухай

Компанийн тухай хуулийн 62.1.9 дэх заалт, ТУЗ-ийн хурлын шийдвэрийг үндэслэн
ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2011 оны санхүүгийн болон үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хангалттай гэж үзсүгэй.
2. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт, тайланг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хэлэлцүүлэхийг ТУЗ-ийн дарга /Б.Батмөнх /-д даалгасугай.

ДАРГА  Б.БАТМӨНХ





СҮЛД-АУДИТ ХХК

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, АУДИТ БАТАЛГААЖУУЛАЛТ, СУРГАЛТ
САНХҮҮГИЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ, ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ.

2012 ОН СЭСАГ 4 өдөр

№ 18

УЛААНБААТАР ХОТ

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Зөрчилгүй санал дүгнэлт

“Шарын гол” Хувьцаат компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлд

Санхүүгийн тайлангуудын талаарх тайлан

Бид “Шарын гол” ХК-ийн 2011 оны 01 дүгээр сарын 01-нээс 2011 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон бэлтгэсэн үлдэгдлийн тэнцэл, орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд, тэмдэглэл, тодруулгад санхүүгийн тайлангийн аудитыг 2011 оны 07 дугаар сарын 2-ны өдрөөс 2012 оны 3 дугаар сарын 16 хүртэл хугацаанд хийж гүйцэтгэлээ.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх хариуцлага

Санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бэлтгэх ба үнэн зөв толилуулах нь удирдлагын үүрэг хариуцлага байна. Энэхүү үүрэг хариуцлагад залилан, алдааны улмаас гарч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайланг бэлтгэх ба үнэн зөв толилуулахад холбогдох дотоод хяналтын системийг бий болгох, хэрэгжүүлэх, хадгалах, түүнчлэн нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгон авч хэрэглэх, тухайн нөхцөл байдалд тохирох нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудыг хийх үүргүүд орно.

Аудиторын хүлээх хариуцлага

Хийж гүйцэтгэсэн аудит дээрээ үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт гаргах нь бидний үүрэг байна. Бид аудитаа Аудитын олон улсын стандартуудын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Эдгээр стандартууд нь санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаагүй эсэх талаар зохистой баталгаажуулалтыг олж авахын тулд аудитаа төлөвлөж, гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудитын ажилд санхүүгийн тайлангууд дахь дүн, тодруулгуудын дагалдах нотолгоог олж авах горимуудыг гүйцэтгэх ажил орно. Санхүүгийн тайлангууд нь алдаа эсвэл залилангийн улмаас гарч болох материаллаг буруу тайлагналтай байж болох эрсдлийг үнэлэх зэрэг горимуудыг аудитор нь өөрийн шийдлээр сонгон авна.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН
/үргэлжлэл/

Тэдгээр эрсдлийн үнэлгээг хийхэд байгууллагын дотоод хяналтын системийн үр нөлөөтэй байдлын талаар дүгнэлт гаргах зорилгоор биш, тухайн нөхцөл байдалд зохистой аудитын горимуудыг гүйцэтгэхийн тулд санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, үнэн зөв танилцуулахтай холбоотой дотоод хяналтыг аудитор авч үздэг.

Мөн аудитын ажилд захирлуудын хийсэн томоохон тооцооллууд ба баримталсан нягтлан бодох бүртгэлийн зарчмуудыг үнэлэх, түүнчлэн санхүүгийн тайлангуудын ерөнхий толилуулагад үнэлэлт өгөх ажлууд орно. Бидний гүйцэтгэсэн аудит нь бидний дүгнэлтэд зохистой үндэслэлийг хангаж өгнө гэдэгт бид итгэлтэй байна.

Дүгнэлт

Бидний дүгнэлтээр 2011 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Шарын гол ХК-ийн санхүүгийн тайлангууд нь санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын Олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ, МНБ
Ч.Гүндбаяр **Ч.ГҮНДБАЯР**
УГНЦ 22
2012 оны 03 дугаар сарын 19-ний өдөр



Санхүүгийн тайлангийн аудит

ШАРЫН ГОЛ ХК-НИЙ
АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
2011 оны 12-р сарын 31-ний өдөр

ҮЗҮҮЛЭЛТ	2010.12.31	/төгрөгөөр/ 2011.12.31
А.ХӨРӨНГӨ		
1.Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,817,858,397.73	17,591,293,226.24
Дансны авлага	5,664,318,214.84	1,192,333,849.92
Бусад авлага	4,995,492.75	10,796,102.46
Найдваргүй авлагын хасагдуулга	(612,138,620.28)	(271,101,427.76)
Бараа материал	1,362,348,606.90	1,297,600,812.12
Мал амьтад	8,414,830.00	8,273,736.98
Урьдчилж төлсөн зардал /тооцоо/	175,745,425.84	175,745,425.84
Эргэлтийн хөрөнгийн дүн	8,421,542,347.78	20,004,941,725.80
2.Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	8,663,388,860.47	9,234,929,275.87
Хуримтлагдсан элэгдэл	(485,908,472.82)	(1,971,935,801.12)
Биет бус хөрөнгө	38,312,696.00	48,694,400.54
Хасагдуулга	(20,433,437.78)	(29,226,426.57)
Хөрөнгө оруулалт ба бусад хөрөнгө		1,074,825,722.89
Хайгууль үнэлгээний зардал	5,921,745,748.03	8,215,354,932.06
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	14,117,105,393.90	16,572,642,103.67
НИЙТ ХӨРӨНГӨ	22,538,647,741.68	36,577,583,829.47
Б.ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
1.Өр төлбөр		
Дансны өглөг	937,408,695.44	1,471,250,484.18
Цалингийн өглөг	86,171,075.00	98,936,907.00
Орлогын татварын өглөг	415,297,352.51	345,581,005.90
ХХОАТ-ын өглөг	58,711,491.64	
НӨАТ-ын өглөг		
Бусад татварын өглөг	19,999,978.07	37,012,889.58
ЭМНД-ийн шимтгэлийн өглөг	23,913,223.89	623,377.00
Банкны богино хугацаат зээл /дахин хөрвөх/	10,421,997,271.56	
Зээлийн хүүгийн өглөг	154,422,693.89	
Бусад өглөг	78,235,250.00	
Урьдчилж орсон орлого	500,000.00	500,000.00
Богино хугацаат өр төлбөрийн дүн	12,196,657,032.00	1,953,904,663.66
Урт хугацаат өглөг	2,508,340,043.20	2,508,340,043.20
Урт хугацаат өр төлбөрийн дүн	2,508,340,043.20	2,508,340,043.20
Өр төлбөрийн дүн	14,704,997,075.20	4,462,244,706.86
2.Эзэмшигчдийн өмч		
Өмч а.Төрийн		
б.Хувийн	723,138,900.00	1,017,024,200.00
Хувьцаат капиталын дүн	723,138,900.00	1,017,024,200.00
Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	1,700,139,876.01	1,700,139,876.01
Дахин үнэлгээний нөөц	7,602,005,526.84	7,602,005,526.84
Хуримтлагдсан ашиг, алдагдал	(2,191,633,636.37)	(1,667,433,371.21)
Тайлангийн үеийн		421,445,093.66
Өмнөх үеийн	(2,191,633,636.37)	(2,088,878,464.87)
Эзэмшигчдийн өмчийн дүн	7,833,650,666.48	32,115,339,122.61
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН	22,538,647,741.68	36,577,583,829.47

Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.
Шарын гол ХК-ний гүйцэтгэх захирал *М.О.О.* С.Насанбат
ерөнхий нягтлан бодогч *Б.О.* Л.Даваасүрэн
Ахлах аудитор *Ч.Г.О.* Ч.Гүндбаяр

Сүлд-Аудит ХХК

хуудас 15



ШАРЫН ГОЛ ХК-НИЙ
АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН
2011 оны 12-р сарын 31-ний өдөр

ҮЗҮҮЛЭЛТ	/төгрөгөөр/	
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	2010.12.31	2011.12.31
Борлуулалтын орлого	10,169,299,082.29	10,551,323,175.40
Борлуулалтын хорогдол ба буцаалт	213,370,683.58	7,839,161.18
Борлуулалтын орлогын дүн	9,955,928,398.71	10,543,484,014.22
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	7,245,790,037.75	8,149,706,380.36
Нийт ашиг /алдагдал/	2,710,138,360.96	2,393,777,633.86
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ		
Үндсэн болон нэмэгдэл цалин	210,043,971.00	601,411,909.00
Нийгмийн даатгалын шимтгэл	27,300,868.00	78,062,446.04
Засвар үйлчилгээний зардал	38,050,401.04	11,172,235.11
Ашиглалтын зардал	11,684,618.46	9,973,037.64
Түрээсийн зардал	5,027,000.00	93,600,448.86
Албан томилолтын зардал	31,088,238.78	96,708,982.76
Тээврийн зардал	35,247,297.72	29,620,800.00
Түүхий эд материалын зардал	32,873,053.11	12,884,350.46
Элэгдлийн зардал	43,615,370.32	88,619,085.37
Зар сурталчилгааны зардал	9,625,182.52	8,653,210.00
Шуудан, холбооны зардал	14,154,320.30	31,472,518.88
Шатахууны зардал	29,074,061.31	35,521,800.30
Шагнал урамшуулалын зардал		4,455,000.00
Хөдөлмөр хамгаалал		8,744,358.59
Бусад зардал	362,245,540.18	1,177,935,678.70
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	850,029,922.74	2,288,835,861.71
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ (АЛДАГДАЛ)	1,860,108,438.22	104,941,772.15
Үндсэн бус үйлдвэрлэл үйлчилгээний ашиг, алдагдал	(329,367,967.69)	(145,581,716.97)
Торгууль, хөнгөлөлтийн ашиг, алдагдал	94,980,975.63	(1,563,552.00)
Валютын ханшийн өөрчлөлтөөс үүссэн ашиг, алдагдал	(288,246,254.22)	(8,602,996.08)
Хувьцаа, бондын зардлын хорогдуулга		
Бусад	(947,699,638.13)	621,384,086.56
Үндсэн бус үйл ажиллагааны ашиг (алд)-ын дүн	(1,470,332,884.41)	465,635,821.51
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	389,775,553.81	570,577,593.66
Орлогын татварын зардал	174,754,320.00	149,132,500.00
Татварын дараах цэвэр ашиг (алдагдал)	215,021,233.81	421,445,093.66

ДАРХАН-УУЛ АЙМАГ
ШАРЫН ГОЛ
Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.
Шарын гол ХК-ний гүйцэтгэх захирал *С.Насанбат* С.Насанбат
ерөнхий нягтлан бодогч *Л.Даваасүрэн* Л.Даваасүрэн
Ахлах аудитор *Ч.Гүндбаяр* Ч.Гүндбаяр
ХУВЬЦААТ КОМПАНИ

ТТА4951-Б. 2050374



Санхүүгийн тайлангийн аудит

ШАРЫН ГОЛ ХК
АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛГИЙН ТАЙЛАН

2011 оны 12-р сарын 31-ний өдөр

Үзүүлэлт	Хувьцаат капитал	Нэмж төлөгдсөн капитал	Дахин үнэлгээний ноц	Гадаад валютын хөрвүүлэлтийн ноц	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт дүн	/пөгрөгөөр/
2010 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	723,138,900.00	-	7,602,005,526.84	1,700,139,876.01	(2,191,633,636.37)	7,833,650,666.48	
Өмчийн дахин үнэлгээний бууралт							
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	723,138,900.00		7,602,005,526.84	1,700,139,876.01	102,755,171.50	102,755,171.50	
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					(2,088,878,464.87)	7,936,405,837.98	
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт							
Ноогдол ашиг							
Тайланг үеийн үр дүн							
Гаргасан хувьцаат капитал	293,885,300.00	23,463,602,890.97				421,445,093.66	
2011 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,017,024,200.00	23,463,602,890.97	7,602,005,526.84	1,700,139,876.01	(1,667,433,371.21)	32,115,339,122.61	

Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү тайлангийн салдгийг хэсэг болно.

Шарын гол ХК-ний гүйцэтгэх захирал:

Ерөнхий нягтлан бодогч: С.Насанбат
Л.Даваасүрэн
Ч.Гүндбаяр

Аудитор:



ТТГ14951-Д-2050374

Сүлд-Аудит ХХК

хуудас 17



**ШАРЫН ГОЛ ХК-НИЙ
АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2011 оны 12-р сарын 31-ний өдөр

ҮЗҮҮЛЭЛТ	/төгрөгөөр/	
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	2010.12.31	2011.12.31
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	12,775,372,557.57	11,577,187,463.20
Борлуулалт болон худалдан авагчдаас орсон мөнгө	11,172,456,200.00	11,542,458,856.77
Туслах үйл ажиллагааны мөнгөн орлого	122,201,400.00	210,000.00
Бусад мөнгөн орлого	1,480,714,957.57	34,518,606.43
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	10,133,303,833.75	13,510,645,352.20
Ажиллагсадад олгосон мөнгө	1,762,641,924.17	2,001,303,554.06
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	672,902,704.00	558,946,000.00
Түүхий эд материал худалдан авахад төлсөн мөнгө	719,987,500.00	19,708,707.59
Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	962,372,300.00	90,863.64
Түлш шатахуун, тээврийн хөлс төлсөн мөнгө	3,821,390,193.51	2,612,316.64
Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн мөнгө	1,122,357,200.00	10,199,357,833.72
Төлсөн хүү, шимтгэл		
Төлсөн орлогын татвар	1,039,327,322.07	554,826,698.91
Даатгалын төлбөрт төлсөн мөнгө	32,324,690.00	
Бусад		173,799,377.64
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	2,642,068,723.82	(1,933,457,889.00)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Хөрөнгө оруулалтын мөнгөн орлого		
Хөрөнгө оруулалтын мөнгөн зарлага	(757,825,384.42)	(31,281,558.33)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(757,825,384.42)	(31,281,558.33)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн орлого		
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн зарлага	(350,963,611.83)	17,738,174,275.84
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(350,963,611.83)	17,738,174,275.84
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,533,279,727.57	15,773,434,828.51
<i>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</i>	284,578,670.16	1,817,858,397.73
<i>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</i>	1,817,858,397.73	17,591,293,226.24

Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

Танилцсан

Шарын гол ХК-ний гүйцэтгэх захирал
ерөнхий нягтлан бодогч

Тайлан баталгаажуулсан



Аудитор

[Signature]

С.Насанбат

[Signature]

Л.Даваасүрэн

[Signature]

Ч.Гүндбаяр

Шарын гол ХК-ийн ХЭ-ийн
2012 оны ... сарын ... ны
өдрийн хурлаар батлав

“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ДҮРЭМ
Шинэчилсэн найруулга

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Шарын гол Хувьцаат компани нь /цаашид компани гэнэ/ бие даасан тайлан тэнцэлтэй, банкинд харилцах данстай, өөрийн нэрийн өмнөөс эрх эдлэн, үүрэг хүлээх ашгийн төлөө үйл ажиллагаа явуулдаг хувьцаа нь нийтэд арилжаалдаг хуулийн этгээд мөн
- 1.2 Компани (цаашид “**Компани**” гэх)-ийн оноосон нэр нь:
Монгол хэлээр: ШАРЫН ГОЛ ХК
Англи хэлээр: SHARYN GOL JSC
- 1.3 Компанийн ажлын үндсэн байрны болон шуудангийн хаяг:

Монгол улс
Дархан-Уул аймаг
Шарын гол сум
Шарын гол ХК-ийн байр
Утас/Факс: +976-7037-2235

- 1.4 Компани нь өөртөө барааны тэмдэг болон бэлэгдэл (эмблем), албан бичгийн хэвлэмэл хуудас, өөрийн нэр бүхий тэмдэг (тамга) хэрэглэнэ.
- 1.5 Компанийн бэлэгдэл, барааны тэмдгийн загварыг ТУЗ баталж, Оюуны өмчийн газар бүртгүүлсэн байна.
- 1.6 Компани нь улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс эхлэн үйл ажиллагаагаа хугацаагүй явуулна

ХОЁР. КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

- 2.1 Компанийн бизнесийн үйл ажиллагааны чиглэл болон түүний үүсгэн байгуулагдсан зорилго нь:
 - 2.1.1 Монгол улсад ашигт малтмалын хайгуул, олборлолт, үнэлгээ хийх болон хэрэв боломжтой гэж үзвэл боловсруулж, тоног төхөөрөмж, өргөн хэрэглээний бараа худалдах, худалдан авах, импортлох, экспортлох зэргээр гадаад, дотоод худалдаа эрхлэх;
 - 2.1.2 Монгол улсын Компанийн тухай хуулийн дагуу байгуулагдсан компанийн явуулж болох эрх зүйн үйлдэл хийх, үйл ажиллагаа явуулах, Монгол улсын

хуулиар аливаа компанид олгосон, олгож болох бүхий л эрх болон давуу эрхийг эдлэх.

ГУРАВ.САЛБАР, ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗАР

- 3.1 Компани нь энэхүү Дүрэм, Монгол улсын хууль тогтоомж буюу хамаарах гадаад улсын хууль тогтоомжийн дагуу өөрийн салбар, төлөөлөгчийн газрыг Монгол улс болон хилийн чанадад байгуулж болно.
- 3.2 Салбар, төлөөлөгчийн газар байгуулах шийдвэрийг ТУЗ гаргана. Тэдгээрийн удирдлагыг ГЗ-ын санал болгосноор ТУЗ томилно.

ДӨРӨВ. КОМПАНИЙН ХӨРӨНГӨ БА ХУВЬЦАА

- 4.1 Компанийн балансад тусгагдсан биет болон биет бус хөрөнгийн нийт дүнгээс компанийн өр төлбөрийг хасаж, үлдсэн хэсэг нь компанийн өөрийн хөрөнгө байна.
- 4.2 Компани нь нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 10,231,389 (Арван сая хоёр зуун гучин нэгэн мянга гурван зуун наян ёсөн) ширхэг энгийн хувьцаа (цаашид “Хувьцаа” гэх) гаргах эрхтэй. Энэ хэмжээнд өөрчлөлт оруулах асуудлыг зөвхөн ХЭ-ийн хурлаар шийдвэрлэнэ.
- 4.2 Дээр дурьдсан хувьцааны хэмжээнд тохируулан хувьцааг гарах шийдвэрийг ТУЗ-ийн хурлаас гаргана.
- 4.3 Компани энгийн хувьцааг заавал гаргах ба үүнээс гадна давуу эрхийн хувьцаа, өрийн бичиг, хувьцаанд хамаарах үнэт цаасыг ТУЗ-ийн шийдвэрийг үндэслэн нээлттэй ба хаалттай хэлбэрээр гаргаж болно.
- 4.4 Давуу эрхийн хувьцаа болон бусад төрлийн үнэт цаасны тоо, нэрлэсэн үнэ, зориулалт, тухайн төрлийн хувьцаа эзэмшигчдэд олгох давуу эрх, тэдний хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын эрхтэй оролцох нөхцөл зэргийг уг үнэт цаасыг гаргах тухай шийдвэрт заана.
- 4.5 Компани өөрийн гаргасан үнэт цаасыг эзэмшигчидтэй нь тохиролцсоны үндсэн дээр худалдан авч болно. Компани энгийн хувьцаанаас бусад үнэт цаасыг бүхэлд нь эсхүл зарим хэсгийг худалдан авч болно. Харин энгийн хувьцааны хувьд тухайн жилд гүйлгээнд байсан нийт хувьцааны дунджийн 25 хувиас илүүгүй байна.
- 4.6 Компани өөрийн гаргасан үнэт цаасыг худалдаж авах шийдвэрийг энгийн хувьцааны 5-аас дээш хувийг худалдаж авахаас бусад тохиолдолд ТУЗ гаргах бөгөөд уг шийдвэртээ худалдаж авах үнэт цаасны төрөл, тоо, үнэ, төлбөр хийх хугацаа, ашиглах журам зэргийг заана.

ТАВ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ

- 5.1 Энгийн хувьцаа эзэмшигч нь дараахь эрх эдэлнэ:
- 1) Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал зарлах үед ТУЗ-өөс тогтоосон “бүртгэлийн өдөр” компанийн хувьцааг эзэмшиж байсан этгээд хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, хэлэлцэж буй бүх асуудлаар өөрийн эзэмшиж буй саналын эрхтэй хувьцаатай хувь тэнцүүлэн санал өгөх
 - 2) ТУЗ-өөс ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн үед давуу эрхийн хувьцаа эзэмшигчидэд ногдол ашиг хуваарилсны дараа эзэмшиж буй хувьцаанд ногдох ногдол ашиг авах,
 - 3) Ногдол ашиг олгохоор зарласан боловч заасан хугацаандаа компанийн буруутай үйл ажиллагаанаас болж олгохгүй бол алданги төлөхийг шаардах
 - 4) Компанийг татан буулгах үед Компанийн тухай хуульд заасан журмын дагуу өр төлбөрийг барагдуулсны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос эзэмшиж буй хувьцаанд ногдох хувь хэмжээгээр хувь хүртэх
 - 5) Компаниас нэмж гаргасан хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах.
- 5.2 Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар доорх асуудлаар шийдвэр гаргахад эсрэг саналтай байсан, эсвэл санал хураалтанд оролцоогүй хувьцаа эзэмшигч бүр өөрийн эзэмшиж буй хувьцааг компанид эргүүлэн авахыг шаардах эрхтэй.
- 1) Нийлэх, нэгдэх, хуваах болон хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөх:
 - 2) их хэмжээний хэлцэл хийх:
 - 3) Компанийн хувьцаа эзэмшигчдийн эрхийг хязгаарласан нэмэлт өөрчлөлтийг оруулсан эсвэл ийм агуулгатай компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах:
- 5.3 Хувьцаа эзэмшигчдангаараа эсвэл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн хамт компанийн энгийн хувьцааны 75-аас дээш хувийг эзэмших тохиолдолд бусад хувьцаа эзэмшигчид нь компанид хувьцаагаа эргүүлэн авахыг шаардах эрхтэй.
- 5.4 Энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч нь ээлжит хурал хуралдахаас ажлын 45 ба түүнээс дээш хоногийн өмнө хурлаар хэлэлцэх асуудлын талаар нэмэлт санал гаргах, компанийн ТУЗ, эсхүл Гүйцэтгэх удирдлагад нэр дэвшүүлэх эрхтэй.
- 5.5 Компани хувьцаа эзэмшигчдийн өмнөөс хариуцлага хүлээхгүй.
- 5.6 Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү эзэмшиж байгаа хувьцааны хэмжээгээр хариуцлага хүлээнэ.
- 5.7 Хувьцаа эзэмшигч нь өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас компанид учруулсан эд хөрөнгийн хохирлыг өөрийн хөрөнгөөр компанийн өмнө хариуцна.

- 5.8 Хувьцаа эзэмшигчдийн хувийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх компанийн хөрөнгөөс тодорхой зааглагдаагүй бол уг хувьцаа эзэмшигч өөрийн бүх эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээр компанийн өр төлбөрийг давхар хариуцна.

ЗУРГАА. КОМПАНИЙН УДИРДЛАГА

- 6.1 Компанийн удирдлага дараахь бүтэцтэй байна:

- 1) Хувьцаа эзэмшигчдийн хурал
- 2) ТУЗ
- 3) Гүйцэтгэх удирдлага

ДОЛОО. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

- 7.1 Компанийн эрх барих дээд байгууллага нь **Хувьцаа эзэмшигчдийн хурал** байна.
- 7.2 Хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит болон ээлжит бус байна.
- 7.3 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг ТУЗ-ийн шийдвэрээр санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор зарлан хуралдуулна. Энэ хугацаанд хурлыг хуралдуулаагүй бол ТУЗ-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулахаас бусад эрх дуусгавар болно.
- 7.4 ХЭХ хуралдуулах шийдвэрийг ТУЗ гаргана
- 7.4.1 ТУЗ-ийн ХЭ-ийн хурал хуралдуулах тухай шийдвэрт дараах зүйлийг заана:
- 1) Хурал хуралдуулах газар, өдөр, цаг;
 - 2) Хурлын хэлэлцэх асуудал
 - 3) Хувьцаат компанийн хувьд хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр;
 - 4) Хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчид мэдэгдэх өдөр, журам;
 - 5) Хуралд бэлтгэх явцад хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалт;
 - 6) Саналын хуудсаар санал авах бол тухайн саналын хуудасны агуулга;
 - 7) Саналын хуудсыг хүлээн авах сүүлчийн өдөр;
 - 8) Хурлын дарга
 - 9) Тооллогын комиссийн дарга, гишүүд.
- 7.4.2 ХЭХ-ыг шийдвэр гаргаснаас хойш 40-өөс доошгүй хоногийн дараа хурал болно
- 7.4.3 Компани ТУЗ-ийн хурал хуралдуулах тухай шийдвэр гаргаснаас хойш 5 хоногийн дотор хурлын зарыг нийтэд мэдээлнэ.
- 7.5 Хурлын зар мэдээнд дараахь зүйлийг заавал тусгана:
- 7.5.1 Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт;
- 7.5.2 Хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцах журам, газар, цаг.
- 7.5.3 Хурал зохион байгуулах комиссын дарга, гишүүдийн утас, электрон шуудангийн хаяг, ажиллах цагийн хуваарь.
- 7.6 Ээлжит хурал хуралдах үед компаниас ХЭ-д дараахь мэдээллийг танилцуулах ажлыг зохион байгуулна:
- 7.6.1 Санхүүгийн болон үйл ажиллагааны жилийн тайлан
- 7.6.2 Санхүүгийн жилийн тайлангийн талаарх аудитын байгууллагын дүгнэлт
- 7.6.3 Тайлангийн жилд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцлүүд

- 7.6.4 ТУЗ-ийн гишүүнээр нэр дэвшсэн хүний тухай танилцуулга;
- 7.6.5 Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд, тэдгээрийн эзэмшлийн хувьцааны төрөл, тоо
- 7.6.6 ТУЗ, ГУ-ын зардал, цалин урамшуулал
- 7.7 Компанийн ТУЗ ээлжитбус хурлыг дараах тохиолдолд хуралдуулна:
 - 7.7.1 Төлөөлөн удирдах зөвлөлийн нийт гишүүдийн талаас дээш хувь нь ажиллах боломжгүй буюу ажиллахгүй болсон
 - 7.7.2 Төлөөлөн удирдах зөвлөлийн 2 буюу түүнээс дээш тооны хараат бус гишүүн, саналын эрхтэй хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигч санал, шаардлага гаргасан
 - 7.7.3 Компанийн алдагдал тухайн тайлант үеийн эцэст өөрийн хөрөнгийн 30 хувиас хэтэрсэн
 - 7.7.4 Компанийн өр нь өөрийн хөрөнгөөс хоёр жил дараалан илүү болж, хасах утгатай болсон
 - 7.7.5 Төлөөлөн удирдах зөвлөл шийдвэр гаргасан;
 - 7.7.6 Аудитын хорооноос ээлжит бус хурал хийхийг шаардсан
- 7.8 Дараах асуудлыг зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ:
 - 7.8.1 Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;
 - 7.8.2 Нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах;
 - 7.8.3 Компанийн өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох;
 - 7.8.4 Компанийн хэлбэрийг өөрчлөх;
 - 7.8.5 Компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;
 - 7.8.6 Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу хувьцаа эзэмшигч нь хувьцаа, бусад үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ хэрэгжүүлэх эсэх;
 - 7.8.7 Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
 - 7.8.8 ТУЗ-с ирүүлсэн саналыг үндэслэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах;
 - 7.8.9 Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох;
 - 7.8.10 Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал;

НАЙМ. ТУЗ

- 8.1 ТУЗ нь ХЭХ-ын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага мөн.
- 8.2 ТУЗ 9 гишүүнтэй байх ба тэдгээрийн 1/3 нь хараат бус гишүүн байна.
- 8.3 ТУЗ-ийн гишүүдийг ХЭХ-аас 2 жилийн хугацаатай томилно.
- 8.4 Хараат бус гишүүн нь дараах шаардлагыг хангасан этгээд байна:
 - 8.4.1 Компанийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшдэггүй

- 8.4.2 Компанид эрх бүхий албан тушаал эрхэлдэггүй, тэдгээрийн удирдлагад ажилддаггүй
- 8.4.3 Төрийн үйлчилгээнээс бусад алба хашдаггүй
- 8.4.4 Компанитай ТУЗ-ийн гишүүнээс бусад хэлбэрээр бизнесийн холбоогүй
- 8.5 Хараат бус гишүүн нь бусад гишүүдийн адил эрх, үүрэгтэй байхаас гадна дараах нэмэлт үүрэгтэй
 - 8.5.1 ТУЗ ба ГУ-ын үйл ажиллагаа, гаргасан бодлого, шийдвэр нь компанийн эрх ашигт сөргөөр нөлөөлсөн эсэх, үйл ажиллагаа нь хууль тогтоомж, дүрэм, журамд нийцсэн эсэхэд хяналт тавих, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчил илэрвэл уг шаардлагыг эс биелүүлбэл уг асуудлыг төлөөлөн удирдах зөвлөлд тавьж шийдвэрлүүлэх, улмаар хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах шаардлагыг хүргүүлэх
 - 8.5.2 Компанийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах талаар ГУ-д үүрэг өгч, хэрэгжилтийг хянах, холбогдох этгээдээс шаардах;
 - 8.5.3 Хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн оролцож, төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн талаар зарчмын зөрүүтэй байр суурьтай байсан бол энэ тухайгаа мэдээлж, хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулах, тодруулга хийх.
- 8.6 Компани шаардлагатай гэж үзвэл тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороог байгуулж болох бөгөөд аудитын, цалин урамшууллын, нэр дэвшүүлэх хороог заавал байгуулж ажиллуулна.
- 8.7 Хороодын гишүүдийн 2/3- нь хараат бус гишүүдээс бүрдэнэ.
- 8.8 Хороо нь тодорхой чиг үүрэгтэй байх бөгөөд тухайн асуудлаар дүгнэлт гаргаж, ТУЗ-д танилцуулан шийдвэр гаргуулах үүрэгтэй.
- 8.9 Аудитын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн байх бөгөөд уг хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулна:
 - 8.9.1 Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих;
 - 8.9.2 Дотоод хяналтын албаны удирдлага, ажилтнуудыг томилох, цалин урамшууллыг тогтоох санал боловсруулах
 - 8.9.3 Аудитын байгууллагыг сонгох, тэдний ажлын хөлсний хэмжээг тогтоох талаар санал боловсруулах;
 - 8.9.4 Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих, дүгнэлт гаргах
- 8.10 Нэр дэвшүүлэх хороо нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
 - 8.10.1 ТУЗ-ийн гишүүн, ГУ-д нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтоох;

- 8.10.2 ТУЗ-ийн гишүүн, ГУ-д нэр дэвшигчидийн ур чадвар, мэдлэг боловсрол, ажлын туршлага, харин хараат бус гишүүдийн хувьд шаардлагыг хангаж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх;
- 8.10.3 ТУЗ-ийн гишүүн, ГУ-д нэр дэвшигчидийг бүртгэн сонгон шалгаруулалт хийж, хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд нэр дэвшүүлэх;
- 8.10.4 ТУЗ-ийн гишүүн, ГУ-ийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх;
- 8.10.5 ГУ-тай байгуулах гэрээний нөхцөлийг боловсруулах;
- 8.10.6 ТУЗ-ийн гишүүдээс бусад компанийн эрх бүхий албан тушаалтны ажлын гүйцэтгэлд гүйцэтгэх удирдлагаас өгсөн үнэлгээнд дүгнэлт гаргах;
- 8.10.7 Бүрэн эрх нь дуусгавар болсноос хойш 3 жилийн хугацаанд аливаа хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд тухайн этгээдийн нэрийг дэвшүүлэхээс татгалзах.
- 8.11 Цалин урамшууллын хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, ТУЗ-д танилцуулна:
 - 8.11.1 ТУЗ-ийн гишүүд, ГУ болон бусад эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, түүний хэрэгжилтэнд хяналт тавих;
 - 8.11.2 ТУЗ-ийн гишүүд, ГУ болон бусад эрх бүхий албан тушаалтанд олгох цалин урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин, урамшуулал олгох санал боловсруулах;
 - 8.11.3 Компанид мөрдөж байгаа ажлын үр дүнтэй холбогдсон компанийн урамшууллын системийн зорилгыг тодорхойлж, үр дүнг үнэлэх
- 8.12 ТУЗ-ийн үйл ажиллагаа явуулах үндсэн хэлбэр нь түүний хурал бөгөөд хурлыг түүний гишүүдийн олонхийн саналаар сонгогдсон дарга удирдана.
- 8.13 ТУЗ-ийн ээлжит хурлыг 2 сард нэг удаа хийх ба шаардлагатай тохиолдолд гишүүдийн аль нэг, ГУ-ын саналаар хэдийд ч хийж болно. Хурлыг ТУЗ-ийн дарга зарлан хуралдуулна.
- 8.14 ТУЗ-ийн хурал болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг ТУЗ өөрөө батлан мөрдөж ажиллана.
- 8.15 Төлөөлөн удирдах зөвлөл нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
 - 8.15.1 Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох;
 - 8.15.2 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;
 - 8.15.3 Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдөр болон хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахтай холбогдох бусад асуудлыг шийдвэрлэх;
 - 8.15.4 Компанийн зарласан хувьцааны төрөл болон тоонд багтаан хувьцаа гаргах;
 - 8.15.5 Компанийн дүрэмд заасан хувьцаанд хамаарах болон бусад үнэт цаас гаргах;
 - 8.15.6 Эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох;
 - 8.15.7 Өөрийн гаргасан хувьцаа, бусад үнэт цаасыг худалдан авах буюу эргүүлэн авах;
 - 8.15.8 Компанийн гүйцэтгэх удирдлагыг сонгох, өөрчлөх, түүний бүрэн эрхийг тогтоох;

- 8.15.9 Компанийн гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөл, түүнд олгох шагнал, урамшуулал, хариуцлагын хэмжээг тогтоох;
- 8.15.10 Аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийг тогтоох;
- 8.15.11 Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргах;
- 8.15.12 Ногдол ашгийн хэмжээ, түүнийг төлөх журмыг тодорхойлох;
- 8.15.13 Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журмыг батлах;
- 8.15.14 Компанийн салбар болон төлөөлөгчийн газар байгуулах;
- 8.15.15 Компанийг өөрчлөн байгуулах талаар хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төслийг бэлтгэх, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;
- 8.15.16 Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
- 8.16 Компанийн тухай хуулийн 76.1.6, 76.1.10, 76.1.17-д заасан асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхэд төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүд заавал оролцож саналаа өгнө.
- 8.17 ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг төлөөлөн удирдах зөвлөлийн даргын санал болгосноор төлөөлөн удирдах зөвлөл томилно
- 8.18 ТУЗ-ийн нарийн бичгийн дарга компанийн эрх бүхийн албан тушаалтанд хамрагдах ба Компанийн тухай хуулийн 82.2-т заагдсан үүргийг биелүүлж ажиллана.

ЕС. ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

- 9.1 Компанийн Гүйцэтгэх удирдлагыг хувь хүн /цаашид “Гүйцэтгэх захирал” гэх/ хэрэгжүүлнэ. Компанийн гүйцэтгэх захирал нь энэ дүрэм болон үр дүнгийн гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдана.
- 9.2 ТУЗ компанийн Гүйцэтгэх захирлыг түүнтэй байгуулах гэрээний үндсэн дээр томилно.
- 9.3 Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн гишүүн болон ТУЗ-ийн дарга, өөр компани, аж ахуйн нэгжийн гүйцэтгэх удирдлагад ажиллахыг хориглоно.
- 9.4 Гүйцэтгэх захирал нь компанийн нэрийн өмнөөс гэрээ хэлэлцээр хийх болон бусад байдлаар компанийг төлөөлөхдөө тусгайлсан итгэмжлэл авахгүй бөгөөд Компанийн тухай Монгол Улсын хууль болон энэ дүрэмд заасан дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
 - 9.4.1 Компанийн хэтийн төлөв, бодлого, үйл ажиллагааны чиглэлийн талаар санал боловсруулах, ТУЗ-ийн хуралд оруулж батлуулах хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
 - 9.4.2 Хараат \охин\ компани, салбар, төлөөлөгчийн газрын захирлуудыг томилох саналыг ТУЗ-д оруулж батлуулах, тэдэнтэй компанийг төлөөлөн контракт гэрээ байгуулах;

- 9.4.3 Компанийн хөрөнгийг ТУЗ-өөс тогтоосон эрх хэмжээнийн хүрээнд захиран зарцуулах:
- 9.4.4 Компанийн дотоод журмыг баталж, мөрдүүлэх:
- 9.4.5 Өөрийн эрх хэмжээний хүрээнд тушаал гаргах:
- 9.4.6 Компанийг төлөөлж гадаад, дотоодын байгууллага, хувь хүмүүстэй харилцаж, ТУЗ-ийн өгсөн чиглэлийн дагуу гэрээ, хэлэлцээр байгуулах:
- 9.4.7 Компанийг төлөөлөх итгэмжлэл олгох:
- 9.4.8 Компанийн бүтээгдэхүүний дотоодод мөрдөх үнэ, тарифыг батлан мөрдүүлэх:
- 9.4.9 Монгол Улсын хууль тогтоомж, шийдвэр болон ТУЗ-ийн тогтоолын биелэлтийг зохион байгуулна. Өөрийн ажлын аппаратыг байгуулж, түүний бүтэц, төсвийг ТУЗ-өөр батлуулан үйл ажиллагаа явуулах:
- 9.4.10 Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцах:
- 9.4.11 Хувьцаа эзэмшигчдийг ТУЗ-ийн хурлын шийдвэр, компанийн санхүүгийн тайлантай танилцах боломжоор хангах:
- 9.4.12 ТУЗ-ийн хуралд компанийн хагас, бүтэн жилийн үйл ажиллагааны талаар тайлагнах.
- 9.5 Гүйцэтгэх удирдлагатай байгуулсан гэрээ цуцалсан буюу цуцлах тухай санал тавьсан тохиолдолд Гүйцэтгэх удирдлагыг шинээр сонгох хүртэл ТУЗ-өөс томилсон этгээд Гүйцэтгэх удирдлагын үүргийг түр гүйцэтгэнэ.
- 9.6 Гүйцэтгэх удирдлага нь ТУЗ-ийн хурал хуралдуулах тухай саналыг ТУЗ-ийн дарга, гишүүнд гаргаж болно.

АРАВ . КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН ТҮҮНИЙ ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

- 10.1 ТУЗ-ийн дарга, гишүүд, Гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нарыг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.
- 10.2 Компанийн эрх бүхий албан тушаалтан нь энэхүү дүрэм, ТУЗ-ийн баталсан дотоод журамд заасан үүргийг биелүүлж, компанийн ашиг сонирхлын төлөө үнэнч шударгаар ажиллана.
- 10.3 Эрх бүхий албан тушаалтан нь ТУЗ-ийн зөвшөөрснөөр бусад тохиолдолд компанийн нууцад хамаарах мэдээ, тайлан, гэрээ, эрхийн холбогдолтой материалыг гуравдагч этгээдэд дамжуулах болон хувийн ашиг сонирхлын төлөө ашиглахыг хориглоно.
- 10.4 Компанийн эрх бүхий албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх, хариуцлагын хэмжээг тогтоох асуудлыг түүнтэй байгуулсан гэрээ, компанийн дотоод журмын дагуу шийдвэрлэх ба боломжгүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ. Хариуцлагыг Компанийн тухай хуульд заасны дагуу хүлээлгэнэ.

АРВАН НЭГ. КОМПАНИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

- 11.1 Компани нь холбогдох хуулиар тогтоосон журмын дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөн санхүүгийн тайлан гаргаж, ХЭ болон эрх бүхий бусад этгээдэд танилцуулна. Санхүүгийн зохицуулах хороо болон хөрөнгийн биржээс тогтоосон

нэмэлт мэдээллийг санхүүгийн тайлангийн хамт дээрхи газруудад зохих хугацаанд нь хүргүүлэн нийтэд мэдээлэх үүрэгтэй.

- 11.2 Компанийн санхүүгийн жилийн эхлэх хугацаа жил бүрийн 1-р сарын 1, дуусах хугацаа 12-р сарын 31 байна.
- 11.3 Компани зохих журмын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах бөгөөд түүний үнэн зөвийг компанийн Гүйцэтгэх захирал хариуцна.
- 11.4 Санхүүгийн тайланд дараахь үндсэн бүрдэл хэсгүүд заавал орсон байна. Үүнд:
 - 1) Баланс
 - 2) Орлого, үр дүнгийн тайлан
 - 3) Мөнгөн гүйлгээний тайлан
 - 4) Хуримтлагдсан ашгийн тайлан;
 - 5) Тухайн тайлангийн хугацаанд хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн жагсаалт, нэр төрөл, үнийн дүн
 - 6) Удирдлагад олгосон цалин, шагнал, урамшил

АРВАН ХОЁР. НОГДОЛ АШГИЙН ХУВААРИЛАЛТ

- 12.1 ТУЗ нь ногдол ашиг хуваарилах эсэх шийдвэрийг санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор гаргах ба ногдол ашиг хувиарлахгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд энэ тухай үндэслэлээ хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд тайлагнана.
- 12.2 ТУЗ нь ногдол ашиг хуваарилах тухай шийдвэртээ хувьцаа бүрт ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй ХЭ-ийн нэрсийн жагсаалт гаргах, бүртгэлийн өдөр болон ногдол ашиг төлөх өдөр зэргийг заасан байна.

Компанийн жилийн санхүүгийн тайлан гарсны дараа дор дурьдсан нөхцөлд цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилна. Үүнд:

- 1) Ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх;
 - 2) Ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, татан буулгалтын үнэ хуульд заасан өөрийн хөрөнгийн доод хэмжээний нийлбэрээс илүү байх;
 - 3) Компани эргүүлэн авах үүрэгтэй үнэт цаасаа бүрэн авсан байх;
- 12.4 Ногдол ашиг хуваарилсны дараа компанийн өөрийн хөрөнгө нь хуваарилахын өмнөх хэмжээнээс 25-аас илүү хувиар багассан тохиолдолд ногдол ашгийг шилжүүлснээс хойш ажлын 15 хоногийн дотор зээлдүүлэгчиддээ өөрийн хөрөнгийн үлдэгдлийн хэмжээг бичгээр мэдэгдэнэ. Энэ үүргийг гүйцэтгэх удирдлага хэрэгжүүлнэ.
 - 12.5 Компани нь ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн бол уг шийдвэрт заасан хугацаанд ногдол ашгийг хуваарилна.
 - 12.6 Ногдол ашгаа аваагүй хувьцаа эзэмшигчийн ногдол ашгийг түүнд төлөх өр болгон нягтлан бодох бүртгэлд хувьцаа эзэмшигчийн нэрээр тусгайлан бүртгэж хадгалах бөгөөд компани хувьцаа эзэмшигчийн анхны шаардлагаар ногдол ашгийг олгох үүрэгтэй.

- 12.7 Ногдол ашиг хуваарилалтын тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор гаргаж, Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон хугацаанд уг хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлнэ.

АРВАН ГУРАВ. КОМПАНИЙН АУДИТОР

- 13.1 Аудитын тухай Монгол улсын хуульд заасны дагуу компани нь гэрээний үндсэн дээр аудиторыг ажиллуулна.
- 13.2 Компанийн ТУЗ аудиторыг сонгож түүнтэй байгуулах гэрээг батална. Гэрээнд компанийн болон аудиторын эрх үүрэг, хариуцлага, аудиторт төлөх хөлсний хэмжээг заана.
- 13.3 Компанийн эрх бүхий албан тушаалтан аудиторын шаардлагаар компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагааны талаарх баримт бичгийг танилцуулах үүрэгтэй.
- 13.4 Аудитор нь хувьцаа эзэмшигчдийн хуралд зөвхөн тайлбар өгөх үүрэгтэй оролцож болно.
- 13.5 Дараах этгээдийг компанийн аудиторроор сонгон ажиллуулахыг хориглоно. Үүнд:
- 1) Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд, компанийн эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл зорилготой этгээд компанийн буюу нэгдмэл сонирхолтой компанийн хөлсний ажилчин;
 - 2) Компанийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн гаргасан үнэт цаас эсвэл Компанийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдэд холбогдох бусад эд хөрөнгө буюу эд хөрөнгийн эрх эзэмшигч;
 - 3) Компанитай аудитаас бусад асуудлаар аливаа хэлцэл хийсэн этгээд.
- 13.6 Аудитор олгох хөлсний хэмжээг түүний гаргасан дүгнэлтийн шинж чанараас хамааруулан тогтоохыг хориглоно.
- 13.7 Аудитор нь дүгнэлтээ зөвхөн бичгээр гаргана.

АРВАН ДӨРӨВ. ЗАРИМ ЧУХАЛ ХЭЛЦЭЛ

- 14.1 Их хэмжээний хэлцэл гэдэгт хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсвэл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл (компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл үүнд хамаарахгүй) компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн гаргалтыг ойлгох бөгөөд уг хэлцлүүдийг Компанийн тухай хуульд заасны дагуу хийнэ.
- 14.2 Сонирхлын зөрчилтэй хэлцэл гэж компанийн тухай хуулийн 89.1-д заасан этгээд эсвэл түүний нэгдмэл сонирхолтой этгээдийн компанитай хийх аливаа гэрээ хэлцэлийг хэлэх ба түүнийг Компанийн тухай хуульд засны дагуу хэрэгжүүлнэ.
- 14.3 Компани тухайн тайлангийн хугацаанд хийсэн их болон сонирхолын зөрчилтэй хэлцэлийн талаархи мэдээлэлийг нийтэд мэдээлэх үүрэгтэй

АРВАН ТАВ. ДҮРМИЙН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

15.1 Компанийн ТУЗ нь энэхүү дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах болон шинэчлэн найруулга хийх тохиолдолд энэ тухай саналыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж батлуулна.

Хувьцаа эзэмшигчдийн 2012 оны -р сарынний
хурлын дугаар тогтоолын хавсралт

Шарынгол” ХК-ийн ТУЗ-ийн 2012 оны зардлын төсөв

д/д	Зардлын төсөв	Нийт зардал м.төг
1.	ТУЗ-ийн дарга	36.000
2.	ТУЗ-ийн гишүүдийн цалин	57.600
3.	НДШ	12.168
4.	Шуудан холбооны зардал	7.380
5.	Бичиг хэргийн зардал	480
6.	Сургалтын зардал /9 хүн 350.0 м.г	3.500
7.	Томилолтын зардал	30.400
8.	Шатахуун	5.200
9.	Зар сурталчилгаа	1.500
10.	Хурлын зардал	800
11.	Зочин хүлээн авалт	12,000
12.	ТУЗ урамшууллын сан	2,000
13.	бусад	750
	ДҮН	169.778



**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2012 оны 2 сарын 06 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Ногдол ашгийн тухай

Компанийн тухай хуулийн 46,47 дугаар зүйл, ногдол ашгийн журмын 1-ийн 2 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Уурхайн уулын ажлын хүндрэл, техникийн парк хуучирснаас зайлшгүй хийгдэх засвар, шинэчлэл, болон шинээр ил уурхайг нээж ашиглах эхний жилүүдэд хөрс хуулалтын коэффициент их байгаагаас зардал өндөр, шаардлагатай хөрөнгө оруулалтын дүн өсч байгаа зэргээс шалтгаалан 2011 оны жилийн ажлын үр дүнгээр ногдол ашиг хуваарилахгүй байхаар тогтоосугай.

ДАРГА  Б.БАТМӨНХ



“Шарынгол”ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол

/төсөл/

2012.4.30.

дугаар01

Шарынгол

**Компанийн жилийн үйл ажиллагааны болон
санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн
дүгнэлт, ТУЗ-ийн ажлын тайлангийн тухай**

Компанийн тухай, хуулийн 62.1.9 дахь заалт, хувьцаа эзэмшигчдийн хурлын тоологын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг зүйтэй гэж үзсүгэй.
2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2011 онд хийсэн ажлыг хангалттай гэж тогтоосугай.

ХУРЛЫН ДАРГА

Б.БАТМӨНХ

“Шарынгол”ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол

/төсөл/

2012.4.30.

дугаар 02

Шарынгол

**Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг
батлах тухай**

Компанийн тухай, хуулийн 62.1.1 дахь заалт, хувьцаа эзэмшигчдийн хурлын тоологын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Шарынгол”ХК-ийн шинэчилсэн найруулга бүхий дүрмийг баталсугай.
2. Улсын бүртгэлийн газарт шинэчилсэн найруулга бүхий дүрмийг хуулийн хугацаанд бүртгүүлэхийг компанийн дүрмийн шинэчилсэн найруулга боловсруулах комисс / Б.Батмөнх/ -д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Б.БАТМӨНХ

“Шарынгол”ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол

/төсөл/

2012.4.30

дугаар03

Шарынгол

**Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2012 оны зардлын төсвийн тухай**

Компанийн тухай хуулийн 62.1.13 дахт заалт, хувьцаа эзэмшигчдийн хурлын тоологоын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2012 оны зардлын төсвийг / хавсралтаар/ баталсугай.
2. Компанийн удирдлагын зардлын төсөвт хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх цалин, урамшууллын хороонд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Б.БАТМӨНХ

“Шарынгол”ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол

/төсөл/

2012.4.30

дугаар 04

Шарынгол

**Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
зарим гишүүдийн эрх үүрэгт өөрчлөлт оруулах тухай**

Компанийн тухай, хуулийн 62.1.7 дахь заалт, хувьцаа эзэмшигчдийн хурлын тоологын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Д.Байлхүү, Ц.Ганбат, Жосеф Найэми нарыг 2012 оны 4 дүгээр сарын 30-ны өдрөөс 2013 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах өдөр хүртэл хугацаагаар компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүний эрх үүрэгтэйгээр ажиллуулсугай.

ХУРЛЫН ДАРГА

Б.БАТМӨНХ

**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИ
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛД САНАЛ АВАХ ХУУДАС**

Хувьцаа эзэмшигчдийн овогнэр.....

Хувьцаа эзэмшигчдийн дансны дугаар
Регистерийн дугаар

Санал өгөх хувьцааны тоо
Бүртгэсэн / Брокер диллерийн компани /
Брокерийн овог нэр

“Шарынгол”ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2012 оны 04 дугаар сарын 30-ны өдрийн 16 цагт Баянгол зочид буудлын хурлын зааланд болно.

№	Хэлэлцэх асуудлууд	Шийдвэр ийн төсөл	Зөвшөөр -сөн	Тат- галз - сан	Түд- гэлз -сэн	Санал
1.	Компанийн 2011 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт бүхий тайлан	Тогтоол 01				
2.	Компанийн дүрмийн шинэчилсэн найруулга	Тогтоол 02				
3.	Компанийн ТУЗ-ийн гишүүдийн 2012 оны цалин урамшуулал болон зардлын төсөв	Тогтоол 03				
4.	Компанийн ТУЗ-ийн зарим гишүүдийн эрх үүрэгт өөрчлөлт оруулах тухай	Тогтоол 04				

Хувьцаа эзэмшигч Гарын үсэг
2012..... сар..... өдөр

САНАЛ АВАХ ХУУДСЫГ АШИГЛАХ САНАМЖ

1. Санал авах хуудасны эхний хэсгийг Зуучлагч брокерийн компанийн ажилтнууд бөглөн тамга даран баталгаажуулан хувьцаа эзэмшигчдэд өгнө
2. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол Зуучлагч брокерийн пүүс дээр очиж хурлын материалтай танилцаад санал авах хуудсаар саналаа өгнө.
3. Засварласан болон балласан, залруулгатай санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
4. Хэрэв та саналаа өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүний овог, нэр, хаягийг дор нь бичиж гарын үсгээ зураад өгч явуулна.

Таныг төлөөлөх хүний овог нэр

Оршин байгаа газрын хаяг

.....

.....

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг

5. Хувьцаа эзэмшигчийн хурлын талаарх мэдээллийг харьяа брокер диллерийн компани болон “Шарынгол”ХК-ийн төв байранд ирж авах буюу 976-11-311073, 99293913, 99031917 утсаар лавлаж болно.
6. Санал авах хуудас хүчингүй болгосон тухай шалтгаан

.....

.....